

**“ШИВЭЭ ОВОО” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2016.11.09

Улаанбаатар хот

“Шивээ Овоо” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг төрийн мэдлийн 90 хувийн хувьцааны эрхийг хэрэгжүүлэгч “Эрдэнэс Монгол” ХХК-ийн санаачилгаар 2016 оны 11 дүгээр сарын 9-ны өдрийн 14.00 цагт Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө-15, Моннис цамхаг 14 давхар “Эрдэнэс Монгол” ХХК-ийн хурлын танхимд хуралдууллаа.

Хувьцаа эзэмшигчдийн хуралд төрийн эзэмшлийн хувьцааны 90 хувийг төлөөлж “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Ц.Түмэнцогт хурал даргалагчаар, хувьцааны 8,9 хувийг эзэмшигч “Fire Bird” сангийн төлөөлөгч Б.Пүрэвбаатар, Би Ди Сек компанийн гүйцэтгэх захирал Д.Даянбилгүүн нар итгэмжлэлээр хувьцаа эзэмшигч Н.Бурмаа, Д.Янжмаа, Ж.Баатар Д.Энхтуяа нар өөрийн биеэр оролцов.

Мөн “Шивээ Овоо” ХК-ийн зүгээс Гүйцэтгэх захирал О.Отгонбаатар, Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга О.Чинхүсэл, Тоологын комиссын дарга С.Одбаяр, гишүүн Х.Дашжаргал А.Энхгэрэл нар мөн оролцлоо. Хурлыг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн удирдамжийн дагуу “Эрдэнэс Монгол” ХХК-ийн төлөөлөгч Ц.Түмэнцогт даргалан явуулахаар боллоо.


О.Чинхүсэл: Хуралд ирсэн төлөөлөгч болон хувьцаа эзэмшигч нарыг танилцууллаа.

Тооллогын комиссын дарга С.Одбаяр: “Шивээ Овоо” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд ирвэл зохих 13,419,101 ширхэг хувьцаа эзэмшдэг 1615 хувьцаа эзэмшигчдээс брокерын пүүсүүдээр дамжуулан хуралд оролцох санал 5 ирсэн байна. 13,223,993 ш хувьцаа эзэмшдэг нийт 7-н хувьцаа эзэмшигчдийг төлөөлж 3 хүн итгэмжлэлээр /үүнээс 2 итгэмжлэгдсэн төлөөлөгч саналын эрхтэй/, 272 ширхэг хувьцаа эзэмшдэг 4 хүн өөрийн биеэр ирж нийт 13,224,265 ш хувьцаатай хувьцаа эзэмшигчид хуралд оролцож хурлын ирц 98,5 хувьтай байна. “Шивээ Овоо” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын ирц бүрдсэн тул хурлыг нээхийг зөвшөөрөх нь зүйтэй байна.

О.Чинхүсэл: Хурлын хэлэлцэх асуудал, дэгийг танилцуулав. “Шивээ-Овоо” ХК-ийн менежментийн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийг компанийн тухай хуулийн 77 дугаар зүйлд заасны дагуу хугацаанаас нь өмнө дуусгавар болгох, шинэчилэн томилох асуудлаар хуралдана.

№	ХУРЛЫН ДЭГ	ХУГАЦАА, ЦАГ, МИНУТ
1	Хурлын ирц мэдээллэх / Зохион байгуулах комисс/	5 минут
2	Хурлын дарга хурлын ажиллагааг нээж, хурлаар хэлэлцэх асуудал, хурлын дэгийг танилцуулах	10 минут
3	Хэлэлцэх асуудлыг дарааллын дагуу танилцуулж хэлэлцүүлэх	Асуудал тус бүр дээр 30 хүртэл минут
4	Хуралд оролцогсдын асуулт, хариулт, санал дүгнэлт авах	Хүн тус бүрээс 5 минут
5	Завсарлага	15 минут

Sign



6	Тооллогын комиссын тогтоолыг танилцуулах	5 минут
7	Хурлаас гарах шийдвэр, тогтоолын төслийг танилцуулах	15 минут
8	Хурлын ажиллагааг хаах	5 минут

Хурлын дарга: “Шивээ-Овоо” ХК-ийн менежментийн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийг компанийн тухай хуулийн 77 дугаар зүйлд заасны дагуу хугацаанаас нь өмнө дуусгавар болгох, шинэчилэн томилох асуудлыг хэлэлцэж байна. Нэр дэвшсэн ердийн болон хараат гишүүдийг танилцуул гэв.

О.Чинхүсэл: Төрийн төлөөллийг хэрэгжүүлэгч “Эрдэнэс Монгол” ХХК-аас дараах 5 хүнийг нэр дэвшүүлсэн байна. Үүнд:

Д/д	Гишүүдийн нэр	Үндсэн ажил
1	Ц.Түмэнцогт	“Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал
2	З.Мэндсайхан	Эрчим хүчний яамны төрийн нарийн бичгийн дарга
3	Д.Ганболд	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Зохион байгуулалтын газрын дарга
4	Э.Алтанзул	Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга
5	Д.Дамба	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны уул уурхайн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн
6	Б.Пүрэвбаатар	Fire bird сангийн монгол дахь төлөөлөгч

Fire Bird” сангийн зүгээс Б.Пүрэвбаатарыг нэр дэвшүүлсэн байна. “Шивээ Овоо” ХК-ийн нэр дэвшүүлэх хорооноос хараат бус гишүүнд дараах 10 хүнийг нэр дэвшүүлсэн байна. Үүнд :

№	Овог нэр	Мэргэжил	Ажилласан туршлага	
			Улсад	Салбарт
1	Ц.Оюунбаатар	Ашиглалтын инженер	36	36
2	С.Баттулга	Уул уурхайн мэргэшсэн инженер	34	34
3	Ц.Нанзад	Уурхайн инженер механик	34	34
4	Д.Түмэннасан	Уул уурхайн зөвлөх инженер	39	39
5	Б.Манлайбаатар	Санхүүгийн удирдлага	8	0
6	Р.Мөнхтуяа	Эдийн засагч	36	0
7	Д.Рагчаасүрэн	Эрх зүйч, өмгөөлөгч	15	2
8	Ч.Болдбаатар	Нягтлан бодогч	27	4
9	Д.Батсүх	Үйлдвэрийн технологич	33	15
10	А.Батзориг	Уул уурхайн менежмент эдийн засагч	10	10

Б.Пүрэвбаатар: Нэр дэвшсэн бүх гишүүдийн дэлгэрэнгүй мэдээллийг сонсмоор байна.

Sign



Хурлын дарга: Бүх анкетыг дэлгэрэнгүй танилцуул гэв.

О.Чинхүсэл: Ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшсэн этгээдийн анкетыг уншиж танилцуулав.

Хурлын дарга: Хурлын дэгийн дагуу энэхүү асуудлаар саналын хуудсыг тарааж санал хурааа гэснээр хурал завсарлав.

Тооллогын комиссын дарга С.Одбаяр: “Шивээ Овоо” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд ирвэл зохих 13,419,101 ширхэг саналын эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс 13,224,265 ширхэг саналын эрх бүхий хувьцаа эзэмшигчид оролцож хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлсэн асуудалд доорх байдлаар саналаа өгсөн байна. Хүчингүй саналын хуудас байхгүй байна. Үүнд:

“Шивээ Овоо” ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүдийг сонгох 13,224,265 саналын эрх буюу кумулятив аргаар нийт 79,345,590 ш саналын эрхээр ТУЗ-ийн ердийн гишүүдийг сонгох санал хураалтыг явуулж 11 ширхэг саналын хуудсаар саналаа өгсөн байна.

Ц.Түмэнцогт	14,493,086 санал
З.Мэндсайхан	14,492,824 санал
Д.Дамба	14,492,824 санал
Д.Ганболд	14,492,824 санал
Э.Алтанзул	14,492,824 санал
Б.Пүрэвбаатар	6,881,007 санал авч ТУЗ-ийн гишүүнд сонгогдох болзлыг хангасан байна.

“Шивээ Овоо” ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүдийг сонгох 13,224,265 саналын эрх буюу кумулятив аргаар нийт 39,672,795 саналын эрхээр санал хураалт явуулж 11 ширхэг саналын хуудсаар саналаа өгсөн байна.

Д.Батсүх	13,214,165 санал
А.Батзориг	12,077,211 санал
Д.Рагчаасүрэн	12,077,211 санал
С.Баттулга	1,137,099 санал
Ц.Оюунбаатар	150 санал
Д.Түмэннасан	401 санал
Б.Манлайбаатар	1,166,533 ш санал тус тус авч Д.Батсүх, А.Батзориг, Д.Рагчаасүрэн нар Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр ажиллах болзолыг хангасан байна гэв.

Хурлын дарга: Хурлаас гарах тогтоолын төслийг танилцуулая.

О.Чинхүсэл: Компанийн тухай хуулийн 62.1.7 дахь заалт, 2016 оны 11 сарын 09-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссын тогтоолыг үндэслэн тус тус ТОГТООХ нь:

“Шивээ Овоо” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдийг 1 дүгээр хавсралтаар Хараат бус гишүүдийг 2 дугаар хавсралтаар 2016 оны 11 дүгээр сарын 09-ны өдрөөс эхлэн сонгосугай. 1 дүгээр хавсралтад:

Д/д	Гишүүдийн нэр	Үндсэн ажил
1	Ц.Түмэнцогт	“Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал
2	З.Мэндсайхан	Эрчим хүчний яамны төрийн нарийн бичгийн дарга

Sign



3	Д.Ганболд	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Зохион байгуулалтын газрын дарга
4	Э.Алтанзул	Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга
5	Д.Дамба	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны уул уурхайн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн
6	Б.Пүрэвбаатар	Fire bird сангийн монгол дахь төлөөлөгч

2 дугаар хавсралтад:

Д/д	Гишүүдийн нэр	Үндсэн ажил
1	Д.Батсүх	Тэтгэвэрт
2	А.Батзориг	"Цэцэнс майнинг" ХХК-ийн ерөнхий эдийн засагч
3	Д.Рагчаасүрэн	Өмгөөлөгч

Тогтоолын төслийн талаар тусгайлсан саналтай хувьцаа эзэмшигч байсангүй. Д.Энхтуяа хувьцаа эзэмшигчийн зүгээс дараагийн Хувьцаа эзэмшигчдийн хурлыг уурхай дээр зохион байгуулах, Төлөөлөн удирдах зөвлөлд нэр дэвшсэн этгээдийг өөрийн биеэр байлцуулах санал тавив. Хувьцаа эзэмшигчдийн хурал 16:30 цагт өндөрлөв.

ХУРЛЫН ДАРГА

Ц.ТҮМЭНЦОГТ

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН

О.ЧИНХҮСЭЛ

Sign